

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 08 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

Г “Ардын эрх” ХК-ийн үнэт цаасыг 7
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 26.1, 29.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 8.1 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2010 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 7/3241 тоот албан бичгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн “Ардын эрх” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 76 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 2 656 500 /*хоёр сая зургаан зуун тавин зургаан мянга таван зуу*/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус *үүрэг болгосугай*.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН